

**“ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН НЭГТГЭЛ” ОНӨААТҮГ ТЭЭВЭРЛЭЛТ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2021 оны 01 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн Газар болон Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилтуудыг Автотээврийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журмын хүрээнд хэрэгжүүлэн ажиллалаа.

НЭГ: БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

Тусгагдсан зорилт: 1.1 Нийслэлийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хангах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний газар 2020 оныг “Нэг хот – нэг стандарт” жил болгон зарлаж хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хөтөлбөрийн дагуу тээвэрлэлт үйлчилгээний хэлтсийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж ажилласан. Биелэлт 100%-тай.

Хүрсэн үр дүн: Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдлыг нэгдсэн 341734, 70044040 утас болон цахим callpro хаягаар авч тээвэрлэлтийн нөхцөлийг сайжруулсан.

Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн дундаж 100 хувь

ХОЁР: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Тусгагдсан зорилт: 2.1 Монгол Улсын Засгийн газрын 2018оны "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах" 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэн ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Монгол Улсын Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 албан даалгаврын дагуу 4 ажлыг төлөвлөгөөний дагуу хийсэн. Биелэлт 100%-тай.

Хүрсэн үр дүн: Төлөвлөгөөний биелэлтийг сар бүрийн 23-ны өдөр захиргаа удирдлага хүний нөөцийн хэлтэст хүргүүлсэн.

Тусгагдсан зорилт: 2.2 Нийслэлийн Засаг даргын №01 болон №04 тоот Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн

№02 дугаар, 2020 оны А.108, А.1242, А.1248, А/1280, А/1320 албан даалгавруудыг тус тус хэрэгжүүлэн ажиллах.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Нийслэлийн Засаг даргын №01 болон №04 тоот Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн №02 дугаар албан даалгавар, 2020 оны Нийслэлийн засаг даргын А/108, А/1242, А/1248, А/1280. А/1320 захирамжуудыг тус тус хэрэгжүүлэн ажилласан. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж ажилласан.

Тусгагдсан зорилт: 2.3 Цаг үеийн холбогдолтой дээд газраас гаргасан тушаал албан даалгавар, шаардлагыг тухай бүр хэрэгжүүлж ажиллах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

2.3.1 Улаанбаатар смарт карт ххк-аас 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 05/001 тоот албан бичигт 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 04:30 цагаас 05:30 цагийн хооронд системийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх зорилгоор “Төлөвлөгөөт ажил” хийгдэх болсныг мэдэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор ээлжийн инженерүүдэд 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдрийн хуваарийг системд урьдчилан оруулах үүрэг даалгавар өгч ажилласан. Хэрэгжилт-100%

2.3.2 Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн газрын хан-уул дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсээс 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр №01 тоот албан мэдэгдлийн дагуу сургалт зохион байгуулж, тухайн зөрчил гаргасан жолоочийг давтан сургалтанд хамруулж, ХАБ-н зааварчилгааг өгч зургаар баримтжуулан 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хариуг өгч ажилласан байна. Хэрэгжилт-100%

2.3.3 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 3/29 тоот албан бичгийн дагуу “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээн”-ний 4.2.2-д “Нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангаж ажиллах, шаардлагатай тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчээс зохицуулалтын арга хэмжээ авсан үед заасан чиглэлд, тогтоосон хугацаанд тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд оруулах” үүргийн дагуу 2020 оны 01 дүгээр сарын 06-ний өдрөөс 10-н хүртэл Ч:7 “Нисэх – Ард кино театр” чиглэлд 2 гаралт нэмэлтээр гаргаж хамтран ажилласан байна. Хэрэгжилт-100%

2.3.4 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 2/106 тоот албан бичгийн дагуу Ерөнхий боловсролын сургуулиудын 3 дугаар улирлын хичээл эхэлж байгаатай холбогдуулан “Сургуулийн автобус”-г гарган

ажиллуулах ажлын хүрээнд С:6А “Ботаник – 1-р сургууль – 45-р сургууль”, С:6Б “Ботаник – 31-р сургууль – 6-р сургууль” чиглэлүүдэд нийт 2 автобус гаргаж ажилласан байна. Хэрэгжилт-100%

2.3.5 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 3/188 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн засаг даргын 2020 оны А/108 дугаар “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд шинэ коронавирусийн эрсдэл, томуу, томуу тест өвчний тохиолдлоос хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор үйлчилгээний эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах тухай зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулж, 7 хоног тутам хариу мэдээг хүргэж ажилласан байна. Хэрэгжилт-100%

2.3.6 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 3/231 тоот албан бичгийн дагуу Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газрын хамтарсан ажлын хэсэг 2020 оны 02 дугаар сарын 06-ний өдрөөс зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ биелэлтийг шалгах ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 07-ний өдөр Нийтийн тээврийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Дөлгөөн, Базаррагчаа, улсын байцаагч Долгорсүрэн, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуйн улсын байцаагч Золбоо нар өглөө 06:00 цагаас 08:00 цаг хүртэл өглөөний гаралтаар 183 автобусанд үзлэг шалгалт хийж, хэрэгжүүлж буй ажлаа дүгнүүлж, сайжруулж ажиллах зөвлөмжийг авч хэрэгжүүлж ажилласан байна. Хэрэгжилт-100%

2.3.7 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 3/247 тоот албан бичгийн дагуу Шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгөгдсөн үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хэрэгжүүлэх, ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа тул дараах ажлуудыг зохион байгуулах:

1. Нийтийн тээврийн хэрэгслүүдэд иж бүрэн угаалга, цэвэрлэгээ, ариутгал тогтмол хийх.
2. Мэргэжлийн хяналтын газраас гаргасан шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэвлэмэл хэлбэрээр олон нийтэд суртчилан мэдээллэх.
3. Ариутгал халдваргүйтгэлийн Тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж нийтийн тээврийн хэрэгслүүдэд ариутгал

халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд нийт 99 шалгагч нарыг зохион байгуулж, 286 тээврийн хэрэгслийн их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн, 2020 оны 02 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээний газрын гаргасан 3 төрлийн зөвлөмжийг нийт 750 ширхэгийг хэвлүүлж 286 автобусны дотор зааланд байрлуулж олон нийтэд мэдээлэл хүргэж, 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр ариутгал халдваргүйтгэлийн мэргэжлийн байгууллагтай хамтран 286 тээврийн хэрэгслийн ариутгаж ажилласан байна.

2.3.8 Нийслэлийн засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн 02-01/832 тоот албан бичиг, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн №04 тоот албан бичгийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээнд амны хаалт зүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлага тавьж, иргэдийг шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу тест өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд иргэний үүргээ биелүүлж үйлчлүүлэх зөвлөмжийг нийт 286 автобусанд байршуулж, мэдээ тайланг нийслэлийн нийтийн тээврийн газарт 7 хоног бүр зурган файлаар баталгаажуулж явуулж ажилласан байна.

2.3.9 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас 2020 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн 1/319 тоот албан бичгийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээг 2020 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 26-ны өдөр хүртэл зогсоосон хугацаанд нийтийн тээврийн автобусны дотор, гадна ариутгал, халдваргүйжүүлэлтийг сайтар хийлгэх, гар ариутгалын бодис байрлуулах бэлтгэл ажлыг 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр нийт 80 шалгагч нараар их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, нийт 286 автобусанд гар ариутгагчийг суурьлуулж ажилласан байна. Хийж хэрэгжүүлсэн ажиллаа 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Нийтийн тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга Мөнхбаярт ажиллаа шалгуулж ажилласан. Хэрэгжилт-100%

2.3.10 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 5/376 тоот албан бичгийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээний жолооч болон тээврийн хэрэгслүүдийн мэдээллийн санг фото зургаар бүрдүүлж 2020 оны 07 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх ажлын хүрээнд хэсгийн дарга нар хариуцсан хэсгийнхээ тээврийн хэрэгсэл болон жолооч нарын зургийг авч бүртгэлийн сан үүсгэж ажиллаж байна.

2.3.11 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн дагуу цаг агаар нэмэх хэмд хүрч, дулаарч эхэлмэгц коронавирусийн тархалтаас урьдчилан

сэргийлэх зорилгоор нийтийн тээврийн хэрэгслүүдийг үйлчилгээнд гарахаас өмнө угаалга, цэвэрлэгээ, ариутгалыг эрчимжүүлж ажиллаж байна.

2.3.12 Тээврийн прокурорын газрын 2020 оны 03 дугаар сарын 17-ний өдрийн дугаар 14 тоот зөрчил арилгах албан бичгийн дагуу зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилтан, албан хаагч, жолооч нарын дунд яриа таниулга хийж, хөдөлмөр хамгаалал аюулгүйн ажиллагааны ээлжит бус давтан зааварчилгааг өгч, зөрчилд холбогдсон жолооч С.Болорчулууныг давтан сургалтанд хамруулж, давтан зааварчилгааг өгүүлж хариу бичгийг 2020 оны 04 дүгээр сарын 03-ний өдөр өгч ажилласан.

2.3.13 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 3/424 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн тээврийн газрын даргын 2015 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Удирдлага, мэдээллийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний

ажлын гүйцэтгэлийг тооцох програм хангамжийн ажиллах зарчим”-д нэмэлт өөрчлөлт оруулах саналаа 2020 оны 03 дугаар сарын 24-ны өдөр Тээвэрлэлт үйлчилгээний хэлтэст хүргүүлж ажилласан.

2.3.14 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 1/581 тоот албан мэдэгдлийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй жолооч нар чиглэл буруу сонгож үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор сарын чиглэлийн орлогын мэдээ буруу гарч, тооцоо судалгаа гаргахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа талаар нийт жолооч нарт нэг бүрчлэн чиглэлээ зөв сонгож шугамын үйлчилгээнд ажиллах заавар, зөвлөмж өгч ажилласан байна.

2.3.15 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 3/588 тоот албан бичгийн дагуу Улсын онцгой комиссоос 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 602 дугаартай албан бичгээр тусгай үүргийн онгоцоор ирэх зорчигчдыг тусгаарлах байр хүртэл тээвэрлэх тээврийн хэрэгслийг бэлдэх ажлын хүрээнд 2 тээврийн хэрэгслийг бэлдэж нийт 4 удаа тусгай үүргийн онгоцоор ирсэн зорчигчдыг тээвэрлэж ажилласан байна.

2.3.16 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 2/621 тоот албан бичгийн дагуу Ковид-19 цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ, дадлага сургуулилат-ыг 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 08:00-18:00 цагийн хооронд хийн иргэдийн хөл хорио, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг бүрэн хаахаар болсонтой холбоотойгоор нийтийн тээврийн үйлчилгээний зарим чиглэлүүдийг зогсоох, уртасгах

буюу тойрч явуулах, богиносгох зэрэг шуурхай зохицуулалтын дагуу Ч:66, Ч:43,Ч:70,Ч:63-чиглэлүүд тойрч явах, Ч:8, Ч:23-р чиглэлүүд бүрэн зогсолт хийж хөдөлгөөний зохицуулалт хийж ажилласан байна.

2.3.17 Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газрын 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01-05/143 тоот хотын стандартын баримт бичиг хүргүүлэх тухай албан бичгийн дагуу нийтийн тээврийн хэмжээнд мөрдүүлэх стандарт, норм, дүрэмд тавигдах шаардлагын баримт бичгүүдийг хүлээн авч нэгтгэлийн нийт 286 тээврийн хэрэгсэл болон жолооч нарт тавих стандарт шаардлагыг хангуулж ажиллаж байна.

2.3.18 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 3/672 тоот албан мэдэгдлийн дагуу Нийтийн тээврийн салбарт гарсан хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг үйлдэгдэж байгаа хэрэг, жолооч нарын зан харилцаатай холбоотой иргэдээс ирүүлж байгаа санал, гомдол зөрчил дутагдал буурахгүй байгаатай холбоотойгоор илэрсэн зөрчлүүдийг арилгаж дахин гаргахгүй байхад анхаарч, нийтийн тээврийн үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу ажил зохион байгуулж ажиллаж байна.

2.3.19 Хан-уул дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсээс 2020 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 27 1-1/3394 тоот албан бичгийн дагуу Монгол улсын их хурлын 2020 оны ээлжит сонгууль болж байгаатай холбогдуулан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2020 оны 06 дугаар сарын 22, 23, 24-ны өдрүүдэд цагдаагийн албан хаагчдыг тээвэрлэхэд ашиглах 4 тээврийн хэрэгслийг бэлэн байдалд ажиллуулж хамтран ажилласан байна.

2.3.20 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 2/773 тоот албан бичгийн дагуу Монгол улсын их хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үед хамгаалалтын үүрэг гүйцэтгэх ажлын хүрээнд цагдаагийн албан хаагчдыг тээвэрлэх зорилгоор 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдрөөс 26-ны өдөр хүртэл нийт 3 өдөр их багтаамжийн 4 автобус гарган тусгай үйлчилгээнд ажиллуулсан байна.

2.3.21 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2/807 тоот албан бичгийн дагуу иргэд эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор нийслэл, дүүрэг, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээнд чанар стандартын шаардлагыг хангуулах зорилтын хүрээнд Нийслэлийн засаг даргын 2020 оны “Хотын стандарт баримт

бичгийг мөрдүүлэх тухай” А/56 дугаар захирамжийн дагуу нийтийн тээврийн үйлчилгээнд мөрдүүлэх стандарт, норм, дүрмээр тавигдах шаардлагын баримт бичгийг хүлээн авч хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллаж байна.

2.3.22 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 3/836 тоот албан мэдэгдлийн дагуу Нийтийн тээврээр үйлчлүүлж байгаа иргэдийн санал гомдлын дагуу дулааны улирал эхэлсэнтэй холбоотойгоор , иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хангах зорилгоор автотээврийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, нийтийн тээврийн үйлчилгээнд тавигдах стандартуудын хэрэгжилт, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн ханган ажиллаж, иргэдэд хүргэж байгаа нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулахад онцгой анхаарч ажиллаж байна.

2.3.23 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 3/837 тоот албан сэрэмжлүүлгийн дагуу цаг агаарын байдал хүндэрч бороо үргэлжлэн орох төлөвтэй байгаа тул үер, усны болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн аюулгүйн ажиллагаа, тээврийн хэрэгслүүдийн техникийн бүрэн бүтэн байдлыг ханган нийтийн тээврийн үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллах талаар онцгой анхаарч мэдээллийн самбарт нийт албан хаагч нарт хандаж сэрэмжлүүлэг мэдээлэл байршуулж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж, шуурхай мэдээлэл солилцох утас болон интернет сүлжээг нээлттэй байлгаж, бэлтгэл автобуснуудыг бэлэн байдалд байлгаж ажилласан байна.

2.3.24 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 3/920 тоот албан мэдэгдлийн дагуу 2020-2021 оны хичээлийн шинэ жил 09 дүгээр сарын 01-ний өдрөөс үе шаттайгаар эхлэхтэй холбоотой нийслэл хотын зорчигч урсгал эрс нэмэгдэж, Ковид-19 халдварын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, нийтийн зорчигч тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ, ариутгалын ажлыг эрчимжүүлэн, иргэдийн аюулгүй орчинд тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, халдвараас урьдчилан сэргийлэх, зорчигчдын тав тухтай зорчих нөхцөл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах, өглөөний эх авалт, оройн буултыг цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж, хөдөлгөөний чиглэл, цагийн хуваарийг чанд баримтлаж, зөрчил дутагдалгүй ажиллах ажлын хүрээнд “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсээс гаргасан удирдамжийн дагуу ажлын төлөвлөгөө гарган нийтийн тээврийн MNS 5012-2011 стандартын хэрэгжилтыг хангуулж, ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж ажилласан байна.

2.3.25 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 3/962 тоот албан мэдэгдлийн дагуу 2020-2021 оны хичээлийн шинэ жил 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэхтэй холбоотойгоор тус газраас “Сургуулийн автобус”-ны үйлчилгээг 09 дүгээр сарын 15-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөж “Сургуулийн автобус”-ны стандарт шаардлагыг мөрдөх, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулж, тээврийн хэрэгслийн таних тэмдэг, хаягжуулалт, автобусны байршлыг тодорхойлох төхөөрөмж, санамж баршуулах, эрүүл ахуйн шаардлага, ариутгал цэвэрлэгээг тогтмол хийх зэрэг бэлтгэл ажлыг зохион байгуулж 3 автобус болон жолооч нарыг бэлдэж, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ээлжит давтан зааварчилгааг өгч ажилласан байна.

2.3.26 Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 27/4531 тоот албан бичгийн дагуу Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулж байгаа “Өнгө нэмье-2020”, “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд тус цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг тээрэлжрүү зөөвөрлөх шаардлагын дагуу 2020 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 2 автобус гарган албан хаагч нарыг тээвэрлэх ажлыг зохион байгуулж хамтран ажилласан байна.

2.3.27 Цагдаагийн ерөнхий газрын тээврийн цагдаагийн албаны 2020 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 15-2/414 тоот албан мэдэгдлийн дагуу замын хөдөлгөөн зохицуулах хэлтсээс 2020 оны эхний 9 сарын байдлаар судалгаа гарган үзэхэд нийтийн тээврийн хэрэгслүүд нь техникийн бүрэн бүтэн байдал хангагдаагүй хөдөлгөөнд оролцож авто замын зорчих хэсэгт эвдэрч, унтарч зогссон, зам тээврийн осол гаргасан зэрэг зохиомол түгжрэл үүсгэсэн байгаа нь замын хөдөлгөөний удирдлагын төвийн хяналтын камерт баримтжуулагдан бүргэгдсэн байгаа тул Монгол улсын замын хөдөлгөөний дүрмийн 27 дугаар зүйлийн 27.2в-д заасан заалтын дагуу тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, Монгол улсын замын хөдөлгөөний дүрмээр сургалт зохион байгуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд зам тээврийн осол зөрчилд холбогдсон нийт 25 жолооч нарыг Нийслэлийн тээврийн прокурор, Нарны зам сургалтын төвтэй хамтарсан сургалтанд 2020 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр хамруулж, мэдээллийн самбар болон замын хуудсаар дамжуулж нийт жолооч нарт зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах анхааруулга, санамж өгч хариуг мэдээ тайланг 2020 оны 09 дүгээр сарын 25-нд хүргүүлж ажилласан.

2.3.28 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 6/1038 тоот албан мэдэгдлийн дагуу Нийслэлийн нийтийн зорчигч тээврийн

үйлчилгээний их, дунд, бага багтаамжийн автобус, троллейбус зэрэг тээврийн хэрэгслүүдэд намрын ээлжит техникийн хяналтын үзлэгийг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс 11 дүгээр сарын 27-ны өдрийг дуустал хугацаанд явуулахтай холбоотойгоор техникийн технологийн албанаас баталсан хуваарийн дагуу тээврийн хэрэгслүүдийг бэлдэж нийт 286 тээврийн хэрэгслийг тэнцүүлж ажилласан байна.

2.3.29 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 5/1036 тоот албан бичгийн дагуу Нийтийн тээврийн хэрэгсэл дотор болон түүний орчимд гарсан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг баримтжуулах, зорчигчдын аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор автобусанд суурьлуулсан хяналтын камерын бүрэн бүтэн байдалд хяналт тавих шалгалыг Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газар, Улаанбаатар смарт карт ххк хамтран 2020 оны 09 дүгээр сарын 17, 18-ны өдөр нийт 286 тээврийн хэрэгслийн хяналтын камерт үзлэг шалгалт хийж ажилласан байна.

2.3.30 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 2/1047 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8 дахь заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сургуулийн автобус” төслийг 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор байгаалийн шахсан /CNG/ хийн түлш зарцуулдаг сургуулийн автобусны түлшний түгээлт тасалдаж нийтийн тээврийн үйлчилгээ доголдсон, сургуулийн автобус төсөл хэрэгжихэд хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул нэмж 10 автобус бэлдэж цагийн хуваарь, чиглэлийн замналын дагуу ажиллуулж байна.

2.3.31 Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 03/5276 тоот албан бичгийн дагуу “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал, мэргэжлийн байгууллагуудын гаргасан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан дотоодын бүх үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлж байгаатай холбогдуулан аж ахуй нэгж байгууллагуудад цах тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж зөвөлгөө өгөх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хяналт тавин ажиллаж байна.

2.3.32 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн 3/1155 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн засаг даргын 2020 оны А/1184 дүгээр “Аймаг, Нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд орон нутгийн хурлын ээлжит сонгуультай

холбогдуулан нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн ажиллагааг хангаж ажиллах талаар зохицуулалт хийж ажилласан байна.

2.3.33 Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 27/1682 тоот албан хүсэлтийн дагуу Хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, цагдаагийн алба үүсэн байгуулагдсаны 100 жилийн тэмдэглэлт ойн баяр 2021 онд тохиохтой холбогдуулан Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагаас “Өнгө нэмье-2020” нөлөөллийн аяны “Хариуцлагатай алба хаагч”, Хүүхдийн эрхийг хамгаалах “Сүүдэр бүү тусга” нөлөөллын арга хэмжээний хүрээнд тус цагдаагийн газрын алба хаагчдын 8-12 насны хүүхдүүдэд цагдаагийн байгууллагын үүсэл хөгжил, түүхэн замнал, уламжлалыг танин ойлгуулах, цагдаа, цэргийн музей үзүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг сурталчлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, эрх үүрэг, зохицуулалтын талаарх ойлголт өгч таниулах, албадуудын онцлог, албаны техник, хувцас, тусгай хэрэгслийн талаар мэдлэг олгох чиглэлээр сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 10-17 цагийн хооронд зохион байгуулах гэж байгаа тул манай байгууллагаас 25 хүний суудалтай 4 автобус гарган хамтран ажилласан байна.

2.3.34 Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 03/6091 тоот албан мэдэгдлийн дагуу Монгол улсын биеийн тамир, спортын тухай хууль, Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоол “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх “Ковид-19” цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор “Дэлхийн алхалтын өдөр”-ийг улс орон даяар 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 31-ний өдрийг хүртэл 10 хоног зохион байгуулах ажлын хүрээнд 2020 оны 11 дүгээр сарын 5-ний өдөр Тээвэрлэлт үйлчилгээний албаны 5 албан хаагчыг зохион байгуулж богд ууланд явган аялал хийж ажилласан байна.

2.3.35 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/1219 тоот албан мэдэгдлийн дагуу Улсын онцгой комиссоос ирүүлсэн коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд” Маскаа зүүцгээе, гараа угаая” 2 дугаар аяныг зохион байгуулах тухай 2020 оны 04 дүгээр албан даалгавар, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 14 дүгээр хурлын тэмлэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг

хангуулах зорилгоор нийслэл, дүүргийн хэмжээнд 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд аян зохион байгуулж, иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг аянд нэгтгэх, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах, чиглэлээр тус газар нь сэрэмжлүүлэг өгч ажиллаж байна. Уг албан мэдэгдлийн ажлын төлөвлөгөө гарган, нийтийн тээврийн хэрэгслийн дотор, гадна ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийлгэх, ариутгалын бодис байрлуулан иргэдийг гараа ариутгах нөхцөлөөр хангах, нийтийн тээврийн үйлчилгээнд амны хаалт зүүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлага тавьж иргэдэд Коронавируст /Ковид-19/ цах тахал, томуу, томуу тест өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар зөвлөмж мэдээлэл хүргэж ажиллаж байна.

2.3.36 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 3/1257 тоот албан мэдэгдлийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ-ний 4.2.4-д Нийтийн тээврийн үйлчилгээний шугам замд эвдэрсэн эсхүл замын хөдөлгөөнд саад учруулж зогссон нийтийн тээврийн хэрэгслийг цаг алдалгүй замаас чөлөөлөх, батлагдсан хуваарийн дагуу чирэгч автомашин ажиллуулж гүйцэтгүүлэх үүргийн дагуу 11 дүгээр сард нийт 10 удаа МУБИС буудал зогсоолд өглөө 7:30 цагаас оройн 22:00 цаг хүртэл бэлэн байдалд ажилласан.

2.3.37 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 3/1290 тоот албан мэдэгдлийн дагуу Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хот хоорондын авто замын хөдөлгөөнийг түр хааж, хотын доторх нийтийн тээврийн үйлчилгээг тусгай хуваарийн дагуу үйлчлэх шийдвэр гарсны дагуу өглөө 06:00-10:00 цаг, орой 17:00-20:00 цагийн хооронд нийт 100 гаралтаар нийтийн тээврийн үйлчилгээг нийслэлийн иргэд хөдөлмөрчдөд үйлчилгээг үзүүлж, өдөр болон орой үйлчилгээнээс буусны дараа бүрэн цэвэрлэж, ариутгал халдваргүйтгэлийн хийж, гар ариутгагч шингэнийг цэнэглэж, нийт жолооч, шалгагч нарыг амны хаалтыг зүүлгэж шугамын үйлчилгээнд ажиллуулж байна.

2.3.38 “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 1/971 тоот албан бичгийн дагуу Монгол улсын засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэл, байгууллагын захирлын А/53 дугаар тушаалын коронавируст /ковид-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийтийн тээврийн үйлчилгээний газраас баталсан цаг

графикийн дагуу өглөө 07:00-10:00 цаг, орой 17:00-22:00 цагуудад нийтийн тээврээр үйлчилгээг үзүүлж, амны хаалтгүй иргэнд үйлчлэхгүй байж, нийтийн тээврийн хэрэгслүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж ажилласан байна.

2.3.39 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 1/1307 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн онцгой комиссоос бүх нийтийн бэлэн байдлыг зэрэгт шилжүүлсэн хугацааг 14 хоногоор сунгасантай холбогдуулан нийслэлийн цагдаагийн газрын коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх эргүүлд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг татан авах, тараах чиглэлд 3 автобус гарган бэлэн байдлыг хангаж ажилласан байна.

2.3.40 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1211 тоот албан бичгийн дагуу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн цаг хугацааг сунгасантай холбогдуулан гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу бэлэн байдлыг хангах мэдээ, мэдээллийг солилцох ажлыг зохион байгуулж, загвар хүснэгтийн дагуу өглөө 8:30, өдөр 14:30, орой 19:30 цагуудад өдөр бүр мэдээгээ өгч ажиллаж байна.

2.3.41 2.3.41 Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 485 тоот зөвлөмжийн дагуу Коронавируст /ковид-19/ халдвараас сэргийлж өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт тавьж, дараах 11 арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт жолооч нарт бэлэн мөнгө зорчигч нараас авахгүй байх, жолоочийн кабинд тусгаарлах хаалт хийж, картаа зайнаас уншуулна уу санамжийг 150 тээврийн хэрэгсэлд байршуулж, зорчигчдын зай хоорондыг бариулж, хамгаалах хэрэгслээр хангаж ажилласан байна.

2.3.42 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 3/1387 тоот албан бичгийн дагуу тус газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01, 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 02 дугаар “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгаврын дагуу нийт жолооч, шалгагч нарт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны ээлжит бус давтан зааварчилгааг 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр өгч, тээврийн хэрэгслийн угаалга, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгүүлж, хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж ажилласан байна.

2.3.43 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 2/1398 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн 370, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 27а/4528 тоот албан бичгүүдэд Коронавируст /Ковид-19/ халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг гүйцэтгэж буй алба

хаагчдыг тусгай маршрутын дагуу тээвэрлэх хүсэлтийн дагуу 1 автобус гарган 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр хүртэл батлагдсан маршрутын дагуу хамтран ажилласан.

2.3.44 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/87 тоот албан бичгийн дагуу Коронавируст халдварт /ковид-19/-аас урьдчилан сэргийлэх Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах ажлын хүрээнд иргэдийг бэлэн мөнгөөр зорчихгүй байх талаар санамж болон жолооч, шалгагч нараар шаардлага тавиулж, жолооч, шалгагч нарыг амны хаалт, малгай, бээлий, нүүрний хаалт, гар халдваргүйжүүлэгчээр хангаж, зорчигч нарыг зай бариж зорчих тэмдэгийг байршуулж, шугам замд тавих хяналтыг эрчимжүүлж шалгагч нарыг ажиллуулж байна.

2.3.45 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 10-ний өдрийн 2/1407 тоот албан бичгийн дагуу Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссоос Коронавируст /Ковид-19/ цар тахлын үед орон нутагт хөл хорионд орсон иргэдийг тээвэрлэх ажлын хүрээнд баталсан хуваарийн дагуу 2020 оны 12 дугаар сарын 14, 18-ний өдрүүдэд 2 автобус гаргаж туснай үйлчилгээнд ажилласан байна.

2.3.46 Нийслэлийн засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/1280 тоот захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

2.3.47 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 3/1465 тоот албан мэдэгдлийн дагуу Нийслэлийн Баянзүрх дүүрэгт коронавирусын тохиолдол илэрсэнтэй холбогдуулан үүсэд буй цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан Баянзүрх дүүргээр дайран өнгөрч үйлчилгээнд ажилладаг чиглэлүүдэд ажилладаг жолооч нарыг бусад жолооч нартай хоорондын зай бариулж, халдвар хамгаалалын дэглэмийг сайтар сахиулах байдлаар ажлаа зохион байгуулж, тухайн чиглэлд нийт 39/55 тээврийн хэрэгсэлд нийт 76 шалгагч нарыг ажиллуулж, тээврийн хэрэгслийн ариутгал цэвэрлэгээнд онцгой анхаарч, халдвар хамгаалалын дэглэмийг сайтар сахиулж ажиллаж байна.

2.3.48 Улаанбаатар смарт карт ххк-ны 2020 оны 12 дугаар сарын 17-ний өдрийн 04/842 тоот албан бичгийн дагуу шалгагчийн цахим картын ашиглах хугацааг 2021 оноор сунгах ажлын хүрээнд нийт 202 шалгагч нарын ажлын картыг хураан авч жагсаалт гарган 2020 оны 12 дугаар сарын 28-ний өдөр сунгалт хийлгүүлж ажилласан.

2.3.49 12 дугаар сарын 08-ны өдрөөс 21-ний өдрүүдэд “Нэгдүгээр бааз дээр коронавирус халдварт өвчин гарсантай холбогдуулан авч хэрэгжүүлэх ажил”, “Хоёрдугаар бааз дээр коронавирус халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж авч хэрэгжүүлэх ажил” удирдамжтай 28 заалт бүхий ажил зохион байгуулж биелэлтэд хяналт тавин ажилласан. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Байгууллагын ажил үйлчилгээ сайжирч, стандартын хэрэгжилт хангагдаж, жолооч нарын сахилга бат дэг журам, ажлын хариуцлага сайжирсан.

Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнгийн дундаж 100 хувь


ГУРАВ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ:

Тусгагдсан зорилт: 3.1 Нийслэлийн Тээврийн Газартай ажил үйлчилгээний гэрээг байгуулан ажиллах:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Нийтийн Тээврийн Үйлчилгээний Газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаархотын доторх 23 чиглэлд ажлын өдөр 222-157 гаралт, амралтын өдөр 183-145 гаралт гаргаж, өглөөний эх авалт 59749 гаралт гаргахаас 59322 гаралт гарган 99.2%, оройн 21 цагаар 58797 гаралт гаргахаас 58363 гаралт гаргаж 99.2-тай, шугам цагийн даалгавар 833516:39:30 цаг ажиллахаас 820835:06:30 цаг ажиллаж, цагийн түвшин 98.4%, рейсийн даалгавар 562259 рейсээс 498418 рейс гүйцэтгэж 88.6%-тай, гэрээний үүргийн биелэлтийг **97%**-тай дүгнэгдсэн. Өмнөх онд 95.13% байсан бөгөөд энэ онд 1.87%-иар өссөн дүнтэй байна.

Хүрсэн үр дүн: Бүрэн хангалттай үнэлгээтэйгээр дүгнүүлж ажилласан.



2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх.


Огноо	Даалгаварт цаг	Гүйцэтгэсэн цаг	Хувь	Гэрээний биелэлт	Үнэлгээ
01-р сар	83007:54:30	81962:44:00	98.7%	96.5%	Бүрэн хангалтай

02-р сар	64665:36:00	63588:16:30	97.8%	96.8%	Бүрэн хангалтай
03-р сар	63721:58:00	63083:53:00	99	97.5%	Бүрэн хангалтай
04-р сард	66418:53:00	66145:04:30	99.6%	93.8%	Бүрэн хангалтай
05-р сард	78496:15:30	78085:22:00	99.45%	95.7%	Бүрэн хангалтай
06-р сард	74610:22:30	73980:37:30	99.15%	96.4%	Бүрэн хангалтай
07-р сард	69538:03:00	68849:09:00	99%	97.1%	Бүрэн хангалтай
08-р сард	69421:35:30	68973:47:00	99.4%	96.3%	Бүрэн хангалтай
09-р сард	72994:11:00	72545:47:00	99.4%	95.5%	Бүрэн хангалтай
10-р сард	73403:33:30	72984:32:00	99.4%	95.7%	Бүрэн хангалтай
11-р сард	52831:32:00	51582:55:30	98%	97.6%	Бүрэн хангалтай
12-р сард	61157:56:30	58715:52:00	96%	95%	Бүрэн хангалтай
Жилийн дүн	833516:39:30	820835:06:30	98.4%		Бүрэн хангалтай

Тусгагдсан зорилт: 3.2 Үйлчилгээний санал гомдол, ашиглалтын саатлыг бууруулах, зам тээврийн осол зөрчилгүй ажиллаж, соён гэгээрүүлэх, сургалт, санамж нэрийн хуудсыг шинэчлэх:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Үйлчилгээний талаар 2020 онд 67гомдол санал ирж, Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газрын улсын байцаагч нартай хамтран жолоочийн буруутай 24, гомдол гаргагчийн буруутай43 байсныг 100% шийдвэрлэн гомдол гаргагчид хариу өгч ажилласан. Үйлчилгээний гомдлын зөрчил гаргасан 24 жолоочийг “Нарны зам” сургалтын төвд зан харилцаа, ёс зүйн сургалтанд хамруулан, шагнал цалинг 5% хасч ажилласан.

Хүрсэн үр дүн: 2019 онд 289 гомдол, 2020 онд 67 гомдол ирж өмнөх оноос 222 гомдлоор буурсан байна. Хэрэгжилт -90%




Тусгагдсан зорилт: 3.3 Ашиглалтын саатлыг бууруулж ажиллах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хөдөлмөр зохион байгуулалтыг оновчтой

хийж ажилласнаар жолоочоос шалтгаалах саатал буурч, ашиглалтын саатал нь 2019 онд 34:17цаг гарсан байсан бол 2020 онд 25:58 цаг ашиглалтын саатал гарсан ба 08:19 цагаар буурсан байна. Хэрэгжилт-90%


Хүрсэн үр дүн: Ашиглалтын саатлыг бууруулж ажилласан.



Тусгагдсан зорилт: 3.4 Осол, зөрчил бууруулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2020 онд Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлээр Зам тээврийн осол 2019 онд 32, 2020 онд 17 бүртгэгдсэн. Зам тээврийн осол, зөрчилд холбогдсон 17 жолоочийг “Нарны зам” сургалтын төвд сургалтанд хамруулж, хурлаар оруулан шагнал цалинг 5% хасч арга хэмжээ тооцон ажилласан. Хэрэгжилт-90%


Хүрсэн үр дүн: Өмнөх оноос осол зөрчил 15-аар буурсан байна.



Тусгагдсан зорилт: 3.5 Замын хөдөлгөөний дүрмийг мөрдүүлж ажиллах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгууль 2019 онд 92 зөрчил, 2020 онд 35 зөрчил гарсан байна. Хэрэгжилт-90%

Хүрсэн үр дүн: өмнөх оноос 57 зөрчлөөр бууруулж ажилласан.



Тусгагдсан зорилт: 3.6 Шугам замд саад учруулсан тээврийн хэрэгслийн тоо бууруулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2020 онд нэгтгэлийн хэмжээнд шугам замд саад учруулсан тээврийн хэрэгсэл 5 бүртгэгдсэн байна. Биелэлт-100%

Хүрсэн үр дүн: 2019 онд 15 бүртгэгдэж байсан ба харицуулахад шугам замд саад учруулсан тээврийн хэрэгслийн зөрчил 10 зөрчлөөр буурсан байна.

**Шугам замд саад учруулж зогссон тээврийн хэрэгслийн
тоог харьцуулбал**



Тусгагдсан зорилт: 3.7 Шугам замд эвдэрч зогссон тээврийн хэрэгслийн тоог бууруулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Шугам замд эвдэрч зогссон тээврийн хэрэгслийн тоо 2019 онд 110, 2020 онд 75 бүртгэгдсэн. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Өмнөх оноос эвдэрсэн тээврийн хэрэгсэл 35 зөрчлөөр буурсан байна.




Тусгагдсан зорилт: 3.8 Зорчигчдод чиглэсэн арга хэмжээний хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.8.1 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас 2020 оны 01 сарын 10-ны өдөр Нийслэлийн статистикийн газрын “Монгол улсын хүн ам, орон сууцны тооллого” –той холбоотой 100ш зурагч хуудас санамжийг нийт 20 автобусны бариуланд байршуулж иргэд зорчигчдод мэдээлэл хүргэж ажилласан байна.



3.8.2 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 3/188 тоот албан бичгийн дагуу Нийслэлийн засаг даргын 2020 оны А/108 дугаар “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд шинэ коронавирусийн эрсдэл, томуу, томуу тест өвчний тохиолдлоос хүн амыг урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор үйлчилгээний эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах тухай зөвлөмжийн дагуу нийт 286 тээврийн хэрэгсэлд эрүүл мэндийн яамнаас гаргасан халдвараас урьдчилан сэргийлэх санамжийг нийт 286 автобусанд байршуулж ажилласан байна.



3.8.3 2020 оны 02 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээний газрын гаргасан 3 төрлийн “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх” зөвлөмжийг нийт 750 ширхэгийг хэвлүүлж 286 автобусны дотор зааланд байрлуулж олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан байна.



3.8.4 2020 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн №04 тоот албан бичгийн дагуу Нийтийн тээврийн үйлчилгээнд амны хаалт зүгээгүй иргэдэд үйлчлэхгүй байх шаардлага тавьж, иргэдийг шинэ коронавирусийн халдвар, томуу, томуу тест

өвчнөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэхэд иргэний үүргээ биелүүлж үйлчлүүлэх зөвлөмжийг нийт 286 автобусанд байршуулж иргэд, зорчигч нарт шаардлага тавьж ажилласан.



3.8.5 Эрүүл мэнд, спортын яамнаас гаргасан шинэ коронавирусээс урьдчилан сэргийлэх аносыг нийт 157 автобусны урд байршуулж ажилласан.



3.8.6 Иргэд зорчигч нарт хандсан Улсын онцгой комиссоос гаргасан халдвараас урьдчилан сэргийлэх 1 төрлийн, Мэргэжлийн хяналтын газраас гаргасан 1 төрлийн наалтуудыг хэвлүүлж нийт 250 автобусанд 300ш наалт наагдсан байна.



3.8.7 Саппорогийн автобусны буудал дээр иргэд зорчигч нарт “Амны хаалтаа зүүж нийтийн тээврээр үйлчлүүлэх” санамж, зөвөлгөө, хяналтаар нийт 4 шалгагч нарыг өглөө 08:00 цагаас оройн 20:00 цаг хүртэл ажлуулж байна.




3.8.8 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр нийт 60 шалгагч нараар их цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, зорчигч нарт зориулсан нийт 286 автобусанд гар ариутгагчийг суурьлуулж ажилласан байна. Хийж хэрэгжүүлсэн ажиллаа 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Нийтийн тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга Мөнхбаярт ажиллаа шалгуулж ажилласан.



3.8.9 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр иргэд зорчигч нарт хандсан “Гэр бүлийн харилцаандаа цаг гаргая” гадна талын 40ш, дотор зааланд байршуулах 500ш, дүүжин бариуланд байршуулах 1800ш уриалга өнгөт наалтыг 286 автобусанд наан байршуулж, мэдээ тайланг НТҮГ мэргэжилтэн Наранцэцэгт өгч ажилласан.



3.8.10 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас 2020 оны 03 дугаар сарын 20-ний өдөр иргэд зорчигч нарт хандсан “Миний гэр аюулгүй орчин” уриалгыг дотор зааланд байршуулах 200ш өнгөт наалтыг 200 автобусанд наан байршуулж ажилласан.



3.8.11 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр “Хотоо соёлтой болгоё” гадна талын 18ш, дотор зааланд байршуулах АЗ хэмжээтэй 257ш, зааланд байршуулах жижиг хэмжээтэй 1475ш уриалга өнгөт наалтыг 286 автобусанд наан байршуулж, мэдээ тайланг НТҮГ мэргэжилтэн Наранцэцэгт өгч ажилласан.




3.8.12 2020 оны 05 дугаар сард Нийслэлийн цагдаагийн газраас гаргасан “Хүчирхийллийг биш хайрыг өвлүүлэе” наалтыг нийт 40 ширхэгийг хэвлүүлж 40 автобусны дотор зааланд байрлуулж олон нийтэд мэдээлэл хүргэж ажилласан байна.

3.8.13 “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ тээвэрлэлт үйлчилгээний хэлтсээс гаргасан “Нэг хот – Нэг стандарт” удирдамжтай ажил ажил зохион байгуулсны дагуу иргэд зорчигч нарт чиглэсэн “Нийтийн тээврээр соёлтой үйлчлүүлцнээе” уриалга гаргаж хоиглох заалт бүхий 280 ширхэг санамжийг 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хэвлүүлж нийт 280 тээврийн хэрэгсэлд байршуулж ажилласан байна.



3.8.14 Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас гаргасан “Шарилжгүй Улаанбаатар” харшлын эсрэг хамтдаа аяны хүрээнд иргэд зорчигч нарт чигэлсэн 250 ширхэг өнгөт зурагт хуудсыг 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдөр нийт 250 тээврийн хэрэгсэлд байршуулж ажилласан байна.



3.8.15 Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанаас гаргасан “Коронавируст халдварт ковид-19 цар тахлаас сэргийлэх заавар, зөвлөмж”-ийн хүрээнд иргэд зорчигч нарт чигэлсэн 200 ширхэг өнгөт зурагт хуудсыг 2020 оны 08 дугаар сарын 16-ны өдөр нийт 200 тээврийн хэрэгсэлд байршуулж ажилласан байна.



3.8.16 Дэлхийн зөн монгол, “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ хамтран гаргасан “Коронавируст халдварт ковид-19 цар тахлаас сэргийлэх заавар, зөвлөмж”-н хүрээнд иргэд зорчигч нарт чигэлсэн 3600 ширхэг өнгөт зурагт хуудас, гар угаах зөвлөмж бүхий комик болон буддаг ном 750ш, видео анимейшин бичлэг 8ш, 2020 оны 09

дүгээр сарын 25-ны өдөр нийт 286 тээврийн хэрэгслийн зорчигчийн дүүжин бариуланд байршуулж ажилласан байна.



3.8.17 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газраас орлогын доод хязгаарыг нэмэгдүүлж ажиллах зорилгоор аж ахуй нэгж байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгээс гаргасан үүрэг даалгаварын дагуу 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн нийт 3 цэгт /Нисэхийн спорт цогцолбор, Хүннү малл, Хөдөлгөөнт/ нийт 6 шалгагч нарыг eзрау пос машиныг ашиглан иргэд зорчигч нарын картыг цэнэглэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Өдөр дунджаар 20000-35000 төгрөгний цэнэглэлт хийж ажилласан.



3.8.18 Нийтийн тээврийн үйлчилгээний газраас гаргасан загварын дагуу коронавирус /ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор, нийтийн тээврийн үйлчилгээнд иргэд, зорчигч нарыг амны хаалтаа зүүж нийтийн тээврээр үйлчлүүлэх, хувийн ариун цэвэрийг сайтар сахих санамжийг нийт 286 тээврийн хэрэгсэлд том наалт 286 ш, жижиг наалт 500 ш өнгөтөөр хэвлүүлж 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр байршуулж ажилласан.




3.8.19 Монгол улсын засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамж, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 15 дугаар хурлын тэмдэглэл, байгууллагын захирлын А/53 дугаар тушаалын коронавируст /ковид-19/ цар тахлын халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Нийтийн тээврийн үйлчилгээний газраас гаргасан баталсан загварын дагуу зорчигч нарыг зай барьж суулгах таних тэмдэгийг 2020 оны 11 дүгээр сарын 14,15-ны өдрүүдэд 3432ш хэвлэж нийт 286 тээврийн хэрэгсэлд байршуулж ажилласан.



3.8.21 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын баталсан хуваарийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 21-ний өдөр хүртэл Монгол кино үйлдвэр, Чингэлтэй эцэс, 5-н шар нийт 3 цэгт хамгаалалтын хувцас, зориулалтын багаж хэрэгслийн хамт нийт 6 шалгагч 3 автобус гарган өглөө 7:00-10:00 цаг, орой 17:00-20:00 цагийн хооронд өдөрт нийт 57 автобусыг рейс тутамд нь ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг хийж ажилласан байна.



3.8.22. 12 дугаар сарын 20-ны өдөр нийтийн тээврийн үйлчилгээний газраас коронавирус халдвараас урьчилан сэргийлэх зөвлөмж бүхий 5 төрлийн 10764 ширхэг санамжийг нийт 283 тээврийн хэрэгсэлд нааж байршуулсан.



Хүрсэн үр дүн: Иргэд, зорчигчдод шинээр баталсан 2020 оны нийтийн тээврийн зорилтийн хүрээнд хууль дүрэм, стандарт, жолооч, шалгагч нарын зан харилцааны хэм хэмжээг, иргэдээс ирэх мэдээллийн дагуу үйлчилгээний чанар сайжирхад ач тусаа өгсөн. Хэрэгжилт 100%

Тусгагдсан зорилт: 3.9 Монгол Улсын нийтийн тээврийн MNS:5012-2011 стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.9.1 Байгууллагын нийт тээврийн хэрэгслийн гаралтын дугаар, нэрийн хуудас, лого, чиглэлийн хаяг, зураглалыг бүрэн хангасан.

3.9.2 Нийтийн тээврийн автобусны жолооч нарт ажлын хувцас, хантааз, цагаан цамцаархангаж, шалгагч нарыг шугамын үйлчилгээний автобусанд зорчигч нарт зөвөлгөө өгөх, төлбөр төлөлтөнд хяналт тавин ажиллуулсан. 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр нийт 600 ширхэг шинэ цэнхэр ажлын подволкоор жолооч нарт хангалт хийж ажилласан байна.



2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр нийт 272 жолоочийн өвлийн хантаазыг олгож ажилласан байна.

2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр баазын эмч Б.Цэрэнпил нийт 202 шалгагч нарт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалалтын хувцас олгож ажилласан байна.



3.9.3 Шугамын үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн гадна, дотор угаалга цэвэрлэгээг, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэж ажилласан. 2020 оны 09 дүгээр сарын 21, 28-ны өдрүүдэд нийт 30 автобусны иж бүрэн шинэ суудлын бүрээс ирж хуучирч муудсан суудлын бүрээснүүдийг сольж шинэчлэж ажилласан байна.


3.9.4 Харилцаа, ёс зүйн, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны давтан зааварчилгааг өгч, иргэд зорчигч нарт хандсан мэдээлэл, анхааруулга, санамжийг автобусны бариул болон зааланд байршуулсан.

3.9.5 Нийслэлийн онцгой комисс, Нийтийн тээврийн үйлчилгээний газар шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд баазын эмч Б.Цэрэнпил шалгагч нарын автобусны гадна, дотор угаалга цэвэрлэгээ, суудлын бүрээсний угаалга, ариутгал халдваргүйтгэлийн ажилд хяналт тавьж, тухай бүрд нь Нийтийн тээврийн үйлчилгээний газрын орлогч дарга Мөнхбаяр, улсын байцаагч хийсэн ажлын тайлан мэдээг зургаар баримтжуулж хүргүүлэн ажиллаж байна.






Өдөр бүр оройн буултаар ариутгал, халдваргүйтгэлийн ажил хийж гүйцэтгэсэн.



Нийт 286 автобусны гадна, дотор заалны их цэвэрлэгээ ариутгал, суудлын бүрээсний угаалга, халдваргүйтгэлийн ажлыг өдөр бүр зохион байгуулан ажиллаж байна.



Үндсэн 23-н чиглэлийн эцсийн буудлуудад өглөө 08:30 цагаас 18:00 цаг хүртэл 16 шалгагч нарыг зохион байгуулж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил хийж ажилласан байна.





Мэргэжлийн “ШИНЭ АРИУСГАЛ”, “САН ХИМИ” ХХК-тай хамтарч 286 автобус, нийт 7564м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 17 удаа зохион байгуулж ажилласан.




1, 2 дугаар баазуудын 2, 2 албан хаагчийг хамгаалалтын хувцас болон багаж хэрэгслээр бүрэн хангаж өдөр бүр өглөө, оройдариутгал халдваргүйжүүлэлтхийж хийж байна.





Нийт 283 автобусны гадна, дотор заалны өдрийн их цэвэрлэгээ ариутгал, суудлын бүрээсний угаалга, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж ажилласан.



Гар ариутгагч шингэнийг тогтмол цэнэглэж ажиллаж байна.



3.9.10 Тээврийн хэрэгслийн угаалга цэвэрлэгээг сайжруулах зорилгоор автобусны заалны гадна шилийг цэвэрлэх багаж хэрэгслээр нийт 100 автобусны жолооч нарт хүлээлгэн өгч хангалт хийн ажилласан байна.



Нийт 100 автобусанд заалны гадна шил арчигч цэвэрлэгээний хэрэгслийг жолооч нарт хүлээлгэн өгсөн.



Баазын эмч Б.Цэрэнпил өдөр бүр жолооч, шалгагч нарын болон байгууллагын инженер техникийн албан хаагч нарын биеийн халууныг тогтмол шалгаж, хяналт тавьж, дархлаа дэмжих Витамин С-г 1 удаа олгож ажилласан байна.





Өдрийн цэвэрлэгээнд өдрийн амралттай болон бэлтгэл, техник үйлчилгээгээ 2-оор зогссон тээврийн хэрэгслүүдийн гадна, дотор заалны зорчигчдын бариул, цонх, гадаргууг угааж ариутгал халдваргүйжүүлэлтийг нийт 25 шалгагч нараар хийлгүүлж ажилласан.



Удирдлагын төв байранд тусгаарлах өрөө гаргаж баазын эмч шаардлагатай эрүүл мэндийн хэрэгсэл байршуулж ажилласан байна.



Нийслэлийн нийтийн тээврийн газрын улсын байцаагч н.Ганбаатар, н. Оюун-эрдэнэ, н.Нарангэрэл нар 2020.06.09,16,18-ны өдрүүдийн өглөөний гаралт, орлогч дарга н.Мөнхбаяр 2020.06.10-ны өдрийн орой бааз дээр ирж цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын явц болон үзлэг шалгалт хийж ажилласан.



Нийслэлийн Зам тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч, Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Отгонсүх 2020.07.31-ны өдөр оройн буултаар нэгдүгээрбааз дээр ирж цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын явцад үзлэг шалгалт хийж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Нийтийн тээврийн стандартын хэрэгжилт бүрэн хангагдсан.

Тусгагдсан зорилт: 3.10 Байгууллагын хөдөлмөр аюулгүй ажиллагааны зохион байгуулалтыг хууль дүрмийн хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: 2020 ондчирэгч автомашины 4 жолооч,аж ахуйн жолооч 5, шугамын үйлчилгээний 517 жолооч, 202 шалгагч нарт өдөр бүр хөдөлмөр хамгаалал аюулгүйн ажиллагааны зааварчилгааг өгч ажилласан. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа бүрэн хангагдсан.

Тусгагдсан зорилт: 3.11 Байгууллагын захирлын тушаалын хэрэгжилтийн дундаж 100 хувь

3.11.1 “Зорчигч тээврийн нэгтгэл” онөөатүг нь GTQ6126BEVBT20 маркийн 8 цахилгаан автобусны туршилтын ажилд 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр гаалийн баталгаат агуулахаас захирлын тушаалаар хүлээн авч, цахилгаан автобусны туршилтын ажилд 2020 оны 02 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн Ч:1 “5-н шар-Офицеруудын ордон” чиглэлд шугамын үйлчилгээнд ажиллуулж эхэлсэн. Цахилгаан автобусны шугаманд туршилт хийсэн мэдээ, илтгэх хуудсыг техник технологийн хэлтэст цаг хугацаанд өгч ажилласан байна.

Тусгагдсан зорилт:3.12 Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тээвэрлэлт үйлчилгээний хэлтэс нь нийтийн тээрийн үйлчилгээний газар болон бусад аж ахуй нэгж байгууллагуудаас ирсэн 75 албан бичгийн хариуг бүрэн хугацаанд нь өгч, 86 албан бичгийг төлөвлөн бусад аж ахуй нэгж байгууллага уруу явуулсан байна.Хэрэгжилт -100%

Хүрсэн үр дүн: Бүрэн шийдвэрлэгдсэн.

Тусгагдсан зорилт:3.13 Шугам замд болон өглөөний гаралт, оройн буултаар хяналт шалгалтын ажил зохион байгуулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.13.1 2020 онд тээвэрлэлт үйлчилгээний хэлтэсболон баазын ИТА нарын баталсан хуваарийн дагуу нийт 23 чиглэлд 13 удаагийн шугам замд, өглөөний гаралтаар 13 удаа, оройн буултаар 12 удаа хяналт шалгалтын ажлыг хийж ажилласан байна.

Шугамын шалгалтаар нийтийн тээврийн MNS 5012-2011 стандартын хэрэгжилтэнд үзлэг хийж, шалгагч нар ажлын байран дээрээ ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж, график цагийг мөрдүүлж илэрсэн зөрчлүүдийг цаг хугацаанд нь арилгаж тайлан мэдээг илтгэх хуудсаар өгч ажилласан.

3.13.2 Нийслэлийн тээврийн газрын тээврийн хяналтын хэлтсээс гаргасан зорчигч тээврийн үйлчилгээний хөлс төлөлтийн байдалд хяналт тавих хамтарсан шалгалтын удирдамжийн дагуу сард 2 удаа өглөө 08:00 цагаас 12:00 цаг, орой 16:00 цагаас 19:00 цаг хүртэл Нийслэлийн тээврийн үйлчилгээний газрын автотээврийн хяналтын улсын байцаагч Бум-эрдэнэ, Б.Мягмардорж, Алтаншагай, Сүхбаатар, Оюун-эрдэнэ, Ахалбек, Батцоож, Долгорсүрэн, Тумбааш, Нарангэрэл нараар ахлуулсан 8 шалгагч нараас бүрдсэн шалгалтын баг 2 автобустай 5 шар, офицеруудын ордоны буудлууд дээр нийтийн тээврийн автобуснуудад зорчигчийн хөлс төлөлтөнд хяналт тавьж, зөрчил гаргасан зорчигч нарт зөрчлийн тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу торгуулийн арга хэмжээ тооцуулан ажилласан.

3.13.3 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын хяналтын хэлтсээс гаргасан удирдамж, чиглэл үүрэг даалгаврын дагуу хуваарьлсан 10 автобусны буудлын зогсоол дээр нийт 20 шалгагч нарыг зохион байгуулж иргэд зорчигч нарт бэлэн мөнгөний зорчилтыг бууруулах хяналтыг тавин ажиллуулж, мөн “зорчигч тээвэр 3” ОНӨААТҮГ шалгагч нарыг ажлын байран дээр ажиллаж байгаа байдалд хяналт тавиулахаар 2 шалгагчийг сар бүр ажиллуулж байна.





3.13.4 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газрын хяналтын хэлтсээс өглөөний эх авалтаар шугамын үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн стандарт хангалт, ариутгал цэвэрлэгээг хийсэн байдалд үзлэг шалгалтыг 2020 онд хяналтын улсын байцаагч Д.Ганбаатар, Д.Тумбааш, н.Нарангэрэл, н.Бэхбал нар 1, 2 дугаар баазууд дээр 11 удаа ирж хийсэн өглөөний гаралтын явцыг шалгасан.

3.13.5. Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээний газрын хяналтын хэлтсээс өгөгдсөн үүрэг даалгаварын дагуу 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн шугамын үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн стандарт хангалт, зорчигчдийн хоорондын зай /1.5-2м/барилт, бэлэн мөнгөөр зорчуулахгүй байх талаар чиглэл өгч нийт 82 шалгагч, офиссийн 40 ажилтан албан хаагч нар 19 автобусны буудалд зогсоож хяналт тавиулж ажилласан. Хэрэгжилт 100%



Хүрсэн үр дүн: Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.

Тусгагдсан зорилт: 3.14 Хөдлөх бүрэлдэхүүний цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавих ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

3.14.1 2020 онд техник үйлчилгээ 2-оор давхалдсан тоогоор орсон 965 автобусны гадна, дотор, суудлын бүрээсийг хэсэг тус бүр ажлын өдрөөр шалгагч нарын хувиарлан ажиллуулж, бүрэн цэвэрлэгээг хийлгэж, суудлын бүрээснүүдийг цэвэрлүүлэн солиулж хэсгийн дарга нар хяналт тавин ажилласан.

3.14.2 Шугам замын хяналт, шалгалтаар үйлчилгээнд ажиллаж байгаа автобусны цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол шалгаж, өдөр бүр оройн буултаар орж ирж байгаа автобусны дотор гадна цэвэрлэгээнд онцгой анхаарч жолооч нараар байнгын чийгтэй цэвэрлэгээг хийлгэж тэрэг тавигч нараар шалгуулж, бүрэн цэвэрлэгээ хийсэн автобунуудыг гараашид оруулж байрлуулан ажиллаж байна. Өглөө бүр шалгах механик шугамын үйлчилгээнд гараж байгаа автобуснуудын цэвэрлэгээг дахин шалгаж, ээлжийн инженерүүд хяналт тавин ажилласан.

3.14.3 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 3/188 тоот албан бичиг, Нийслэлийн засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамжийн дагуу “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйжүүлэлт”-н ажлын төлөвлөгөө гарган, оройн буултаар нийт 32 шалгагч, эцсийн буудлын ариутгалын ажилд 8 шалгагч, өдрийн цонхолж орж ирэх болон өдрийн амралттай, техник үйлчилгээ 2-оор орж байгаа автобуснуудын цэвэрлэгээ ариутгалын ажилд 32 шалгагч гарган баазын эмч ариутгалын бодисоор өдөр бүр хангаж төлөвлөгөөний дагуу ажилласан байна.

3.14.4.2020 оны Нийслэлийн Засаг даргын А/1242, А/1248, А/1280 дугаар захирамжуудын дагуу нийт хөдлөх бүрэлдэхүүнд нийт 50 шалгагчийг хувиарлан өглөө, өдөр, орой угаалга цэвэрлэгээ, ариутгалыг тогтмол хийж ажилласан.



Хүрсэн үр дүн: Үйлчилгээний чанар сайжирсан. Хэрэгжилт 100%

Тусгагдсан зорилт: 3.15 Техникийн хаврын үзлэг оношилгоонд бүрэн орж тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011 стандартыг хангах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Хаврын техникийн үзлэг оношилгоо 2020 оны 03 дугаар сарын 16-наас эхэлсэн бөгөөд 2020 оны 05 дугаар сарын 31-нд хүртэл Нийтийн тээврийн үйлчилгээний газраас гаргасан хуваарийндагуу нийт 283 автобусны хуваарийн зохицуулалт болон бэлтгэл ажлыг хийлгэж бүрэн тэнцүүлж ажилласан байна.

Намрын техникийн хяналтын үзлэг оношилгоо 2020 оны 09 дүгээр сарын 21-нээс эхэлсэн бөгөөд 2020 оны 12 дүгээр сарын 30-нд дуусахаар Нийтийн тээврийн үйлчилгээний газраас хуваарь ирсэн. Техникийн үзлэг оношилгоонд баталсан хуваарийн дагуу нийт 283 автобусны хуваарийн зохицуулалт болон бэлтгэл ажлыг хийлгэж тэнцүүлж ажилласан байна. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Техникийн бүрэн бүтэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдал сайжирч стандартын шаардлага бүрэн хангагдсан.

Тусгагдсан зорилт: 3.16 Баталсан хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Техник технологийн хэлтсээс баталсан хуваарийн дагуу техник үйлчилгээ 1-ээр давхардсан тоогоор 790 автобус, техник үйлчилгээ2-оор 965автобуснуудыг хуваарийн дагуу хөдөлгөөний зохицуулалт хийж техник үйлчилгээнд бүрэн хамруулсан байна.Хэрэгжилт 100%-тай.

Хүрсэн үр дүн: Техникийн бэлэн байдлыг бүрэн хангаж ажилласан.

Тусгагдсан зорилт: 3.17 Жолооч нарын мэргэшсэн үнэмлэхний хугацааг сунгах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Мэргэшсэн жолооны үнэмлэхтэй 517 жолооч ажиллахаас Автотээврийн үндэсний төв, “Нарны зам” сургалтын төвд мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хугацаа дууссан 87 жолоочийг сургалтанд хамруулж мэргэшсэн үнэмлэхний хугацааг сунгуулж ажилласан.Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Мэргэшсэн жолоочоор бүрэн хангагдсан.

Тусгагдсан зорилт: 3.18 Техникийн шуурхай тусламжийн автомашиныг бэлэнд байдалд ажиллуулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Чирэгч автомашины 4 жолооч нарыг баталсан хуваарийн дагуу ээлжинд гарч, баазуудын харъяанд байгаа чирэгч автомашиныг ээлжинд гарах хугацаандаа хариуцан бэлэн байдалд

ажилласан.Нийтийн тээврийн үйлчилгээний газраас гаргасан хуваарийн дагуу 92 удаа МУБИС буудал зогсоолд өглөө 7:30 цагаас оройн 22:00 цаг хүртэл бэлэн байдалд ажилласан. 2020 оны 01 дүгээр сарын 19-нд чирэгч автомашиныг үзлэгт оруулан тэнцүүлж, дуут дохионы зөвшөөрлийг сунгуулан ажилласан .Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Замын хөдөлгөөнд ачаалал, саад учруулалгүй техникийн шуурхай тусламжийг хүргэсэн.

Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн дундаж 95хувь

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Тусгагдсан зорилт: 4.1 Тээвэрлэлт үйлчилгээний хэлтэс үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, зохион байгуулалтыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан тухай бүр шинэчилсэн байдал:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тээвэрлэлт үйлчилгээний хэлтсийн цаг үеийн холбогдолтой үйл ажиллагааг олон нийтэд таниулах ажлын хүрээнд “Нийтийн тээвэр”, “Зорчигч тээврийн нэгтгэл” facebook хуудсаар болон мэдээллийн самбараар мэдээлэл хүргэж, албаны ажлын үр дүн, тайланг 7 хоног, сар улирлаар нэгтгэлийн өргөтгөсөн нэгдсэн шуурхай хуралд ажиллаа танилцуулж мэдээллэсэн. Хэрэгжилт 100%.

Хүрсэн үр дүн: Хэлтэс, албаны үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр цахим хуудсаар, мэдээллийн самбараар олон нийтэд мэдээ мэдээлэл өгч ажилласан.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын дундаж 100 хувь

ТАВДУГААР БҮЛЭГ: БУСАД МЭДЭЭЛЭЛ

Тусгагдсан зорилт: 5.1 Ажилчдын ажил амралтын хуваарийг батлан мөрдүүлэх ажлын хүрээнд.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа: Тээвэрлэлт үйлчилгээний хэлтэс нь бүтцээр хэлтсийн дарга 1, ашиглалтын инженер 1, ахлах инженер 2, хэсгийн дарга 8, ээлжийн инженер 8, аж ахуйн жолооч 11, шугамын автобусны 517 жолооч, 202 шалгагч, нийт 750 ажилтантай ажилласан байна. 2020 онд:

- Ээлжийн амралттай: жолооч- 506, шалгагч-109
- Өвдсөн: жолооч-215,шалгагч-96
- Чөлөөтэй: жолооч-15, шалгагч-4, ИТА-0
- Хуулийн мэдэлд: жолооч-2
- Асуудал шийдэх: жолооч-25, шалгагч-9

- Жирэмсний амралттай: шалгагч-23

Хүрсэн үр дүн: Хөдөлмөр зохион байгуулалт оновчтой хийж байгууллагын үйл ажиллагаа жигд явагдсан.

Тусгагдсан зорилт: 5.2 Хэлтэс, алба, хэсгүүдийн хурлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.2.1 2020 онд нэгтгэлийн өргөтгөсөн шуурхайд 7 удаа, хэлтсийн өргөтгөсөн хуралд 12 удаа хийж цаг үеийн мэдээлэл солилцож үүрэг даалгавар авч ажилласан.

5.2.2 Албаны хурлыг 12 удаа хэсгийн дарга, ээлжийн инженерүүдэд хийж 2019 оны ажлын үзүүлэлт, тайлан гаргаж 2020 оны төлөвлөгөөний дагуу ажиллах зэрэг ажил үүргийн заавар, үүрэг даалгавар өгч, цаг үеийн мэдээ мэдээлэл хийж ажилласан.

5.2.3 Хэсгүүдийн хурлыг 2020 онд 7 удаа зохион байгуулж нийт жолооч нарт хурал хийн 2019 оны тайланг тавьж, 2020 онд үйлчилгээний гомдолгүй, аваар осолгүй, сахилга бат дэг журам, ажлын хариуцлагыг дээшлүүлж соёлтой үйлчлэх талаар заавар зөвөлгөө, цаг үеийн холбоотой мэдээ мэдээлэл, үүрэг даалгавар өгч ажилласан.

5.2.4 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр, 2 дугаар сарын 12-ны өдөр, 10 дугаар сарын 16-ны өдөр нийт шалгагч нарын хурлыг зохион байгуулж цаг үеийн холбоотой мэдээлэл өгч, шугаманд хяналтаар ажиллах зааварчилгааг өгч ажилласан.
Хэрэгжилт 100%


Хүрсэн үр дүн: Ажлын уялдаа холбоо сайжирсан.

Тусгагдсан зорилт: 5.3 Замын цагдаа болон мэргэжлийн багштай хамтарсан хичээл сургалтыг тогтмол явуулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.3.1 Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн газрын хан-уул дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсээс 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр №01 тоот албан мэдэгдлийн дагуу сургалт зохион байгуулж, тухайн зөрчил гаргасан жолоочийг давтан сургалтанд хамруулж, ХАБ-н зааварчилгааг өгч зургаар баримтжуулан 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хариуг өгч ажилласан байна.

5.3.2 2020 оны 08 дугаар сарын 24, 25, 26, 27-ны өдрүүдэд “Нарны зам” сургалтын төвөөс зохион байгуулсан зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зан харилцаа ёс зүйн сэдэвт сургалтыг багш Б.Төөрүүл, н.Баярмаа нар зохион байгуулж нийт 334 жолооч нар хамрагдсан байна. “Нарны зам” сургалтын төвд зам тээврийн осол, үйлчилгээний гомдлын зөрчил гаргасан 43 жолоочийг давтан сургалтанд хамруулж ажилласан.



5.3.3 2020 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Хан-уул дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Дэлхийн зөн, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтарсан “Сүүдэр бүү тусга” хүүхдийн эрх хамгааллын сэдэвт сургалтанд нийт 52 жолооч нар хамрагдсан байна.



5.3.4 2020 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг Нийслэлийн тээврийн прокурорын газар, “Нарны зам” сургалтын төвтэй хамтран зохион байгуулж нийт 35 жолооч нарыг сургалтад хамруулан, ээлжит бус давтан зааварчилгааг өгч ажилласан байна.



Нийслэлийн тээврийн прокурорын газрын хяналтын прокурор н.Оюунжаргал, н.Анар, “Нарны зам” сургалтын төвийн багш Б.Төөрүүл нар жолооч нарт сургалт хийсэн.

5.3.5 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газрын хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан шалгагч нарын ажлын байрны зорилго, хийх ажлын чиг үүргийн талаар 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр “Ситибаз” ХХК дээр сургалт хийж, энэхүү сургалтанд нийт 44 шалгагч нарыг хамруулж ажилласан байна.

5.3.6 Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний газрын хяналт, шалгалтын хэлтсээс зохион байгуулсан шалгагч нарын ажлын байрны зорилго, хийх ажлын чиг үүргийн талаар 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 1-р бааз дээр сургалт хийж, энэхүү сургалтанд нийт 30 шалгагч нарыг хамруулж ажилласан байна.



5.3.7 “Нарны зам” сургалтын төвд зам тээврийн осол гаргасан нийт 77 жолооч, үйлчилгээний гомдол зөрчил гаргасан 41 жолооч нарыг зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зан харилцааны зөрчилгүй ажиллах сэдэвт сургалтанд хамруулж ажилласан. Хэрэгжилт 100%

Хүрсэн үр дүн: Зам тээврийн осол зөрчил, үйлчилгээний гомдол, үйлчилгээний чанар дээшилсэн.

Тусгагдсан зорилт: 5.4 Бүх нийтийн их цэвэрлэгээний ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.4.1 2020 онд нийт 24 удаа буюу сард 2 удаа 8 хэсгийн нийт жолооч нар хариуцсан талбайн цас мөс, хог шороог цэвэрлэж ажилласан байна. Хэрэгжилт 100%





Хүрсэн үр дүн: Цэвэр цэмцгэр орчин бүрдсэн.

Тусгагдсан зорилт: 5.5 Ажилчдыг нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт хамруулах, баазын эмчээр жолооч нарын биеийн байдлыг тогтмол шалгуулж ажилд гаргах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.5.1 Баазуудын эмч нар 7 хоногт 2-3 удаа буюу 2020 онд 144 удаа өглөө, оройн гаралтаар ирж шугаманд ажилласан жолооч, хяналтын ажилтан нарын эрүүл мэндийн үзлэгийг тогтмол хийж, амны хаалт болон гар ариутгагч, дархлаа дэмжих витамин С, халуун аарцаар хангаж ажилласан. Мөн ажлын өдөр ажлын цагаар нийт ажилчин албан хаагчидад эрүүл мэндийн урдчилсан үзлэг, зөвлөгөөг өгч ажилласан байна. Нэгдүгээр бааз дээр коронавируст халдварт өвчин илэрсэнтэй холбоотойгоор 2020 оны 12 дугаар сарын 03, 04, 11-ний өдрүүдэд коронавирусын PCR шинжилгээг 3 удаа нийт жолооч, шалгагч, инженер техникийн ажилтан албан хаагч нарын бүрэн хамруулж ажилласан байна. Хэрэгжилт 100%



Хүрсэн үр дүн: Өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан.

Тусгагдсан зорилт: 5.6 Эрүүл цэвэр агаар сэдэвт арга хэмжээ зохион байгуулна.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.6.1 2020 оны 01 дүгээр сард Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан цасны баярын арга хэмжээ цуцлагдсан байна.

5.6.2 2020 оны 11 дүгээр сарын 05-ний өдөр “Ковид-19” цар тахлын үед иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын ажилтан албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, дархлааг дэмжих зорилгоор “Дэлхийн алхалтын өдөр”-ийг улс орон даяар зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээний хүрээнд 1 дүгээр баазын 20 ажилтан алба хаагчид Богд ууланд алхалт хийж, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.



Хүрсэн үр дүн: Явган аялалд амжилттай оролцсон.

Тусгагдсан зорилт: 5.7 Олон жил үр бүтээлтэй ажилласан ажилтан ажиллагсдыг төрийн болон салбарын шагналд тодорхойлох ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.7.1 2020 оны 01 дүгээр сард “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНААТҮГ-н 2019 оны ажлын үр дүнг дүгнэж, ажил бүтээлээрээ шалгарсан шилдэг ажилчдын нэрсийг гаргаж захиргаа удирдлагын хэлтэсд хэлэлцэж шалгаруулж ажилласан. Хэрэгжилт-100%

Хүрсэн үр дүн: Ажилчдын шагнаж урамшуулсан.

Тусгагдсан зорилт: 5.8 Баяр ёслолын өдрүүдэд бэлэн байдалд, сахилга баттай, хяналтыг сайжруулж, хариуцлагатай эргүүл жижүүрийн ажил хийж гүйцэтгэж ажиллах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.8.1 2020 оны 01 дүгээр сарын 01, 02 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд 1, 2 дугаар баазуудын даргын баталсан хуваарийн дагуу байгууллага дээр болон байгууллага ойр орчим эргүүл шалгалт, сахилга хариуцлагыг чангатгах, ээлжийн ажилчдын ажлын зохион байгуулалт, галын аюулгүйн байдал бүрэн хангагдсан эсэхэд тээвэрлэлт үйлчилгээний албаны ИТА нар 4 удаа шөнийн 02:00 цагаас 04:00 цаг хүртэл, 9 удаа өглөө 09:00 цагаас оройн 22:00 цаг хүртэл хуваарийн дагуу эргүүл жижүүрийн ажил хийн ажилласан.

5.8.2 Нийтийн тээврийн үйлчилгээний газрын 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 3/188 тоот албан бичиг, Нийслэлийн засаг даргын 2020 оны А/108 дугаар захирамжийн дагуу “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйжүүлэлт”-н ажлын хүрээнд баазын даргын баталсан хуваарийн дагуу орой 20:00 цагаас 23:00 цаг хүртэл ариутгал, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтэнд тээвэрлэлт үйлчилгээний албаны нийт 9 албан хаагч нар 48 удаа хяналт, хариуцлагатай жижүүрээр ажилласан байна. Хэрэгжилт- 100%

Хүрсэн үр дүн: Баяр ёслолын өдрүүдэд ноцтой гарсан зөрчилгүй ажилласан.

Тусгагдсан зорилт: 5.9 Цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан замын нөхцөл байдал хүндэрч зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.9.1 2020 онд нийт жолооч нарт хурал хийж, цаг агаарын нөхцөл шалтгаан болзошгүй аваар ослоос сэргийлж, анхаарал болгоомжтой хурдаа зөв тохируулж явах, тээврийн хэрэгсэл хуучирсан тул техникийн бүрэн байдал, цахилгааны эвдрэл гэмтэлтэй тээврийн хэрэгсэлтэй ажил үйлчилгээнд гарахгүй байх талаар нийт жолооч нарт анхааруулга санамж өгч, мэдээллийн самбарт анхааруулга, санамж, сэрэмжлүүлэг байршуулж ажилласан.

Хүрсэн үр дүн: Цаг агаарын хүндрэлтэй үед зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлж чадсан.

Тусгагдсан зорилт: 5.10 Смартын онлайн камерын тоног төхөөрөмж хүлээлцэх ажлын хүрээнд:

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.7.1 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл “Улаанбаатар смарт карт” ХХК, 1, 2 дугаар баазуудын тээвэрлэлт үйлчилгээний албаны ахлах инженер, хэсгийн дарга нарын хамт нийт 279 автобусны смарт онлайн

камерын тоног төхөөрөмжүүдийг нэг бүрчлэн хүлээлцэж, нийт 511 жолооч нарт хүлээлгэн өгч ажилласан байна.

Хүрсэн үр дүн: Онлайн камерыг жолооч нарт хүлээлгэн өгснөөр аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, нийтийн тээврийн стандарт хангалтад хяналт тавигдах бүрэн боломжтой болсон. Хэрэгжилт 100%

Тусгагдсан зорилт: 5.11 Тэмдэглэлт өдрүүдэд байгууллагын болон жолооч, шалгагч нарт чигэлсэн ажилд зохион байгуулалттай оролцох.

Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.11.1 2020 оны 05 дугаар сарын 29, 30, 31-ний өдрүүдэд “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах” өдрийг тохиолдуулж нийт жолооч, шалгагч нарын хүүхдүүдэд зориулж бэлэг тараах ажлыг зохион байгуулж баярын мэнд дэвшүүлж ажилласан байна. Хэрэгжилт-100%

5.11.2. Шинэ жилийн баяраар нийт ажилтан албан хаагч нарын ар гэрт гарын бэлгийг нэгтгэлийн захирлын мэндчилгээний хамт хүргүүлэн ажилласан.

Хүрсэн үр дүн: Байгууллагын үйл ажиллагаа болон жолооч, шалгагч нарын урам зориг, ажилчдын дунд эвсэг уур амьсгал бүрдэж, хамт олны эв нэгдэл, ажиллах эрч хүч сайжирна.

Дүгнэлт

Ололттой тал:

- Үйлчилгээний гомдолын зөрчил өмнөх оны мөн үетэй харьцуулахад 222 гомдолоор буурсан.
- Ашиглалтын саатал 17:22 цагаар буурсан байна.
- Нийтийн тээврийн үйлчилгээний газрын бүртгэлээр зам тээврийн осол зөрчил 15 зөрчлөөр буурсан.
- Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн торгууль өмнөх оноос 57 зөрчлөөр буурсан.
- Шугам замд саад учруулсан зөрчил өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 зөрчлөөр буурсан байна.
- Шугам замд эвдэрч зогссон тээврийн хэрэгслийн тоо 35-аар буурсан.
- Угаалга цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, стандарт мөрдөлт сайн.

Сул тал:

- Смартын цагийн нийт гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,3%-аар буурсан.

- Зам тээврийн осол зөрчлийн тоо буурсан боловч хүний амь нас эрсдсэн осол 2 гарсан байна.

Д/д	Үзүүлэлтүүд	Дундаж хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилт	100%
2	Тогтоол шийдвэрийн хэрэгжилт	100%
3	Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүн	95%
4	Байгууллагын үйл ажилллагааны ил тод байдал	100%
5	Бусад мэдээлэл	100%
Нийт		99%

ХЯНАСАН:
ТЭЭВЭРЛЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА
ТАЙЛАН БИЧСЭН:
АШИГЛАЛТЫН ИНЖЕНЕР

М.ЦЭНД
Ч.ОТГОНЖАРГАЛ